

**ЗХАНЗХ-ны Байгаль орчны хорооны үйл
ажиллагааны тайлан(2020 он)**



Япон улс, Тояама муж
(2021.3)

Дараалал

1 2020 оны төслийн хэрэгжилтийн байдал	1
(1) Төслийн санал	1
(2) Төсөлд оролцогч талууд	1
(3) Төслийн хэрэгжилтийн байдал	2
2 2021 оны төслийн санал, төсөлд оролцох хүсэлтэй орон нутгууд.....	7
(1) Төслийн санал	7
(2) Төсөл бүрээрх санал	7
(3) Төсөлд оролцох хүсэлтэй орон нутгууд	18
3 Хорооны дараагийн зохицуулагч болох хүсэлтэй орон нутгийн судалгааны үр дүн...	19
4 Байгаль орчны хорооны үйл ажиллагааны төлөвлөгөө (2021 он)	19

1 2020 оны төслийн хэрэгжилтийн байдал

(1) Төслийн санал

Төслийн нэр	Санаачлагч	Тайлбар
Зүүн хойд Азийн залуучуудыг байгаль орчны үйл ажиллагааны манлайлагчид бэлтгэх хөтөлбөр	Тояама муж	Зогсоосон
Далайн хог хаягдлыг багасгах тухай дадлага хөтөлбөр	Тояама муж	
Зүүн хойд Азийн байгаль орчны зурагт хуудасны үзэсгэлэн	Чүнчоннам муж	Зогсоосон
Далайн амьд биетийн тухай судалгаа	Тояама муж	
Хясаанд тулгуурласан цэвэр нүүрстөрөгчийн тухай хүүхэд сурагчдад зориулсан байгаль орчны танин мэдэхүйн хөтөлбөр	Чүнчоннам муж	Зогсоосон
「Eco-selfie – Байгаль орчныг хамгаалах үйл ажиллагаа сельфи зурагт」 гэрэл зургийн уралдаан	Томск муж	

※Зүүн хойд Азийн хүүхэд залуучуудыг байгаль орчны үйл ажиллагааны манлайлагчид бэлтгэх хөтөлбөр, Зүүн хойд Азийн байгаль орчны сэдэвт зурагт хуудасны үзэсгэлэн, хясаанд тулгуурласан цэнхэр нүүрстөрөгчийн тухай хүүхэд сурагчдад зориулсан танин мэдэхүйн хөтөлбөрийг ковид 19 цар тахлын тархалтаас сэргийлэхийн тулд зогсоосон.

(2) Төсөлд оролцогч (◎ : Төслийн санаачлагч, ○ : Төсөлд оролцогч орон нутаг,

△ : Хэрэгжүүлээгүй зогсоосон төсөлд оролцох хүсэлтэй орон нутаг)

Орон нутаг ^{※1}		Төсөл	Байгаль орчны үйл ажиллагааны манлайлагч	Далайн хог хаягдал ^{※2}	Зурагт хуудасны үзэсгэлэн	Далайн хог хаягдлын судалгаа	Цэнхэр нүүрстөрөгч	Гэрэл зургийн уралдаан
Хятад	Шаньси муж	△	—	—	—	—	—	—
	Ляонин муж	△	—	—	—	—	—	—
Япон	Ямагата муж	—	○S	—	—	—	—	—
	Тояама муж	◎	◎	△	◎	△	○	○
	Ишикава муж	—	○S	—	○	—	—	—
	Фүкүй муж	—	○S	—	○	—	—	—
	Киото муж	—	○S	—	—	—	—	—
	Тоттори муж	—	○S	—	○	—	—	—
	Шиманэ муж	—	○S	—	—	—	—	—
	Ямагүчи муж	—	○S	—	—	—	—	—
	Сага муж	—	○S	—	—	—	—	—
	Нагасаки муж	—	○S	—	—	—	—	—
Солонгос	Ганвон муж	△	○S	△	—	—	—	—
	Чүнчоннам муж	△	—	◎	—	◎	—	—
	Гёнсаннам муж	△	○S	—	—	—	—	—
Орос	Приморийн хязгаар	△	○S	△	○	△	○	○
	Хабаровск хязгаар	△	—	△	—	△	○	○
	Эрхүү муж	△	—	△	—	—	◎	◎
	Томск муж	—	—	—	—	—	—	○

	Кемеров муж	—	—	—	—	—	○
Оролцогч орон нутаг (Оролцох хүсэлтэй орон нутаг)	4 улс (9 орон нутаг)	3 улс 13 орон нутаг	3 улс (6 орон нутаг)	2 улс 5 орон нутаг	3 улс (4 орон нутаг)	2 улс 6 орон нутаг	

※ 1. Доогуур зураастай орон нутаг : ЗХАНЗХ (NEAR) -ны гишүүн бус орон нутаг

※ 2. ○S : Далайн хог хаягдлын судалгааны үйл ажиллагаа ба хог хаягдлаар урлагийн бүтээл хийж буй/зөвхөн цахимаар үйл ажиллагааг харуулна.

(3) Төслийн хэрэгжилтийн байдал

【Далайн хог хаягдлыг арилгах тухай сургалт, хөтөлбөр】

1 Үндэслэл, зорилго

Далайн хог хаягдлын судалгаа ба Баруун хойд Номхон далайн эргийн дагуух орон нутгуудын үйл ажиллагааг хамруулсан хог хаягдлын гаралтыг зогсоох тухай сургалт дадлагын хөтөлбөр явуулж дээд урсгал хэсгээс эргийн бүс хүртэлх далайн хог хаягдлын асуудлын талаарх ойлголтыг нэмэгдүүлж, хүүхэд сурагч, нутгийн иргэдэд хог хаягдлыг хаяхгүй байх, далайн орчныг хамгаалах ухамсарыг төлөвшүүлж, өдөр тутмын амьдралдаа хэрэгжүүлж, далайн хог хаягдлыг зогсоох үйл ажиллагааг эрчимжүүлнэ

2. Агуулга

Хүүхэд сурагч, ард иргэдийн оролцоогоор дамжуулан хог хаягдлын судалгаа болон хог хаягдлын гаралтыг зогсоох арга хэмжээний талаар сургалт явуулна. Мөн боломжтой орон нутгаас далайн хог хаягдал болон өрхийн хаягдал материал ашиглан урлагийн бүтээл хийнэ.

(1) Далайн хог хаягдлын судалгаа

а. Хугацаа

2020 оны 6-11 сар (Намар явуулахад тохиромжтой)

б. Судалгаа хийх газар

Төсөлд оролцогч орон нутгуудын далай (Эх газрын гол мөрөн хамаарахгүй) -н эргийн бүс

в. Судалгаа хийх арга

- Тухайн орон нутгаас нутгийн бага, дунд, ахлах сургууль, төрийн бус байгууллагын оролцоотой хийнэ.
- Судалгааны үйл ажиллагааны зэрэгцээ далайн хог хаягдлын гаралтыг зогсоох тухай сургалт явуулна.
- Судалгааны үр дүнг Тояама муж(Олон нийтийн эрх ашгийн төлөөх хууль ёсны байгууллага болох NPEC) бүхэлд нь хариуцан гаргана.
- 2018 оноос судалгааны төрөлд бичил хуванцар (5mm-ээс доош диаметртай хуванцар хог) нэмж оруулсан (хялбаршуулсан судалгаа явуулна)

г. Төсөлд оролцогч орон нутаг

3 улс, 13 орон нутаг

Япон : Ямагата муж, Тояама муж, Ишикава муж, Фүкүй муж, Киото муж,
Тоттори муж, Шиманэ муж, Ямагүчи муж Сага муж, Нагасаки муж

Солонгос : Ганвон муж, Гёнсаннам муж

Орос : Приморийн хязгаар

д. Оны төлөвлөгөө

5, 7 сарын төслийн танилцуулга, оролцох заавар, судалгааны хүснэгт явуулах
5 сараас төсөлд бэлдэж, төслийг хэрэгжүүлэх

е. Бусад



Далайн хог хаягдлын судалгаа хийж буй байдал (Тояама муж)

(2) Далайн хог хаягдлаар урлагийн бүтээл хийх

а. Хугацаа

Жилийн турш

б. Болох газар

Төсөлд оролцогч орон нутаг

в. Төсөл хэрэгжүүлэх арга

Тояама мужаас гаргасан зааварчилга ашиглан тухайн орон нутгийн бодит байдалд тааруулан нутгийн арди иргэд сурагчдийн оролцоотой зохион байгуулна.

г.Төсөлд оролцогч орон нутаг

Япон улс : Тояама муж

д. Жилийн төлөвлөгөө

5,7 сарын төслийн танилцуулга, зааварчилга, судалгааны хүснэгт явуулах

5 сараас төсөлд бэлдэж хэрэгжүүлэх

е. Бусад



Далайн хог хаягдлаар бүтээл хийж буй байдал (Тояама муж)

【Далай тэнгисийн эргийн амьд биетийн судалгаа】

1 Үндэслэл, зорилго

Зүүн хойд Азийн бүсийн далайн амьд биетийн олон янз байдлыг хамгаалахын тулд тухайн бүсэд амьдарч буй амьд биетийн тухай мэдээлэл цуглуулах, далайн гадаргууны амьд биетийн судалгааг явуулна. Уг судалгаагаар дамжуулан жирийн ард иргэд, хүүхэд залуучуудын далайн амьд биетийн талаарх сонирхлыг нэмэгдүүлж, байгаль орчныг хамгаалах, амьд биетийнолон янз байдлыг хамгаалах ухамсрыг төрүүлнэ.

2 Агуулга

(1) Хугацаа

2020 оны 7-9 сар

(2) Болсон газар

Төсөлд оролцогч орон нутгийн далайн эрэг

(3) Төсөл явуулсан арга

- NPEC-ээс гаргасан судалгаа хийх зааварчилга ашиглан судалгааг явуулж судалгааны үр дүнг төсөлд оролцогч орон нутгуудтай хуваалцсан.
- Далайн амьд биетийн талаарх мэдлэгтэй судалгааны байгууллага, NGO/NPO, мэргэжилтнүүд голчлон чиглүүлж, нутгийн ард иргэд, хүүхэд залуучууд хамт оролцон далайн амьд биетийг цуглуулж, ажиглан амьд биетийн нэр зургийг тэмдэглэсэн.
- Дэлхийн дулаарал, гаднаас ирсэн амьд биетийн талаарх гадаргуу дээр ил гарсан амьд биетийн оршин тогтнож байгаа эсэхийг шалгасан.
- Судалгааны үр дүнг NPEC сангаас цэгцэлж вэбсайтд мэдээллийг тараасан.

(4) Төсөлд оролцсон орон нутаг

2 улс, 5 орон нутаг

Япон : Тояама муж, Ишикава муж, Фүкүй муж, Тоттори муж

Орос : Приморийн хязгаар

(5) Оны төлөвлөгөө

5 ~ 7 сар : Төсөлд оролцогчдыг бүртгэсэн.

7 ~ 9 сар : Судалгааг явуулсан

(6) Бусад



Судалгаа явуулж буй байдал (Тояама муж)

「Eco-selfie – Байгаль орчныг хамгаалах үйл ажиллагаа сельфи зурагт」 сэдэвт гэрэл зургийн уралдаан

1. Байгаль орчныг хамгаалах сэдвээр гэрэл зургийн уралдаан зохион явуулж байгаль орчныг хамгаалах үйл ажиллагаанд иргэдийн оролцоог нэмэгдүүлж, байгаль орчныг хамгаалах ухамсрыг төрүүлнэ.

2. Агуулга

(1) Хугацаа

2020 оны 6.22~12.20

(2) Болсон газар

Томск муж

(3) Явуулсан арга

① Орон нутгуудаас ирүүлсэн байгаль орчныг хамгаалах сэдэвт гэрэл зургийг бүртгэсэн.

② Орон нутгуудаас уралдаанд оролцуулах гэрэл зургийг Томск мужийн захиргаа болон NPEC руу явуулсан.

③ Томск мужийн захиргаанаас гэрэл зургийн илэрхийлэл, байгаль орчныг хамгаалах үйл ажиллагааны агуулга зэргийн шалгуураар шилдэг бүтээлд өргөмжлөл олгосон

④ Томск мужийн захиргаанаас бүтээлээ явуулсан орон нутгуудын шагналт байрын эздэд шагнал, бэлэг, нийт оролцогчдод батламжийг шуудангаар илгээсэн.

⑤ Уралдаанд иргэдээ оролцуулсан орон нутгуудийн захиргаанаас шагналт байрын эзэд болон оролцсон хүмүүст шагнал, батламжийг гардуулсан.

⑥ Томск мужийн захиргаанаас сошиалаар шилдэг бүтээлүүдийг танилцуулсан.

(4) Уралдаанд оролцсон орон нутаг

2 улс, 6 орон нутаг

Япон : Тояама муж

Орос : Приморийн хязгаар, Хабаровск хязгаар, Томск муж, Эрхүү муж, Кемеров муж

※ Уралдаанд ирүүлсэн бүтээлийн тоо : 115 (2020 оны 11 сарын 23-ны байдлаар)

(ангилал)

Ой моджуулалт • цэвэрлэгээний үйл ажиллагаа : 39 бүтээл

Амьдралын булаг (Цэвэр усны орчин) : 54 бүтээл

Эко амьдрал (Байгаль орчинд ээлтэй амьдрал) : 22 бүтээл

(5) Жилийн төлөвлөгөө

6 сарын 22-ны өдрөөс 11 сарын 1-ний өдрийг хүртэл орон нутгийн захиргаанаас оролцогчдыг бүртгэх. Дараагийн шатанд Томск мужаас оролцогчдын бүтээлийг бүртгэх

11 сард Томск мужийн захиргаа уралдааныг шалгаруулах

12 сард Томск мужийн захиргаанаас уралдааны шагналыг шуудангаар илгээх сошиалаар шилдэг бүтээлийг танилцуулах

(6) Бусад

Уралдаанд оролцсон бүтээлийг танилцуулсан Томск мужийн байгаль орчныг хамгаалах • нөөц ашиглалтын зөвлөлийн SNS (VKontakte)

https://vk.com/album-126197212_275617592



Уралдаанд ирүүлсэн гэрэл зураг (Хэсгээс нь оруулав)

2. 2021 оны төсөл, төслийн санаачлагч, оролцогч

(1) Төслийн санаачлага

Төслийн нэр	Төслийн санаачлагч
Зүүн хойд Азийн хүүхэд залуучуудыг байгаль орчны үйл ажиллагааны манлайлагчид бэлтгэх хөтөлбөр	Тояама муж
Далайн хог хаягдлын гаралтыг зогсоох тухай сургалт дадлага, хөтөлбөр	Тояама муж
Зүүн хойд Азийн байгаль орчны гэрэл зургийн үзэсгэлэн	Чүнчоннам муж
Далайн эргийн амьд биетийн судалгаа	Тояама муж
Хясаанд тулгуурласан цэнхэр нүүрстөрөгчийн тухай хүүхэд сурагчдад зориулсан байгаль орчны танин мэдэхүйн хөтөлбөр	Чүнчоннам муж
「Eco-selfie – Байгаль орчныг хамгаалах үйл ажиллагаа сельфи зургаар」 сэдэвт гэрэл зургийн уралдаан	Томск муж

(2) Төслийн агуулга

【Зүүн хойд Азийн хүүхэд залуучуудыг байгаль орчныг хамгаалах үйл ажиллагааны манлайлагчид бэлтгэх хөтөлбөр】

1. Үндэслэл, зорилго

Зүүн хойд Азийн хүүхэд сурагчид (дунд, ахлах сургуулийн сурагч) SDGs • байгаль орчны асуудлын талаар лекц сонсох, санал бодол солилцох, байгаль орчныг хамгаалах үйл ажиллагаанд оролцох зэргээр нөхөрөл, харилцан ойлголцлыг нэмэгдүүлж, нийгмийн тогтвортой нөхцөл байдлын төлөө байгаль орчныг хамгаалах, хадгалах боловсон хүчнийг бэлтгэнэ.

2. Агуулга

(1) Хугацаа

2021 оны 8 сард

(2) Болох газар

Тояама муж

(3) Явуулах арга

- 1 жил тутамд Солонгос • Япон • Хятад • Оросын орон нутгуудад дараалан зохион байгуулна.
- Төсөл хэрэгжүүлэх газраас төслийн агуулгыг шийднэ.
- SDGs • байгаль орчны асуудлын талаарх лекц сонсох, санал бодол солилцох, байгаль орчныг хамгаалан хадгалах үйл ажиллагааг явуулах

(4) Жилийн төлөвлөгөө

5 сард оролцогчдыг бүртгэнэ

8 сард төслийн явуулна.

(5) Найдаж буй үр дүн

- Тогтвортой нийгмийг бий болгохын чухлыг ойлгож, глобал цаг үед бүс, орон нутгийн байгаль орчныг хамгаалах үйл ажилагааг манлайлах боловсон хүчнийг төрүүлэн гаргана.
- Хөтөлбөрөөр дамжуулан байгаль орчны асуудлыг шийдэхэд хамтдаа хичээх бодол төрж, олон улсын сүлжээг байгуулна.

(6) Бусад

Зүүн хойд Азийн бүсэд ковид 19 халдварт өвчний байдлаас үүдэн хөтөлбөрийг

зогсоож болно.

3. Төсөлд оролцогчд орон нутгуудад тавигдах шаардлага

(1) Хамтран ажиллах шаардлага

Төсөлд оролцогч орон нутгуудаас оролцогчдыг бүртгэж, төсөл удирдан явуулах орон нутаг руу илгээнэ.

(2) Зардал

. Зардал

Төсөл явуулах газарт хүрч очих зардлыг тухайн төсөлд оролцогч орон нутгаас хариуцна. Мөн хөтөлбөрт оролцоход гарах байр хоолны зардал, арга хэмжээний зардлыг тухайн хөтөлбөрийг зохион байгуулагч орон нутаг хариуцна.

(3) Оролцох хүрээ

NEAR-ын гишүүн орон нутгууд

【Далайн хог хаягдлын гаралтыг зогсоох тухай дадлага сургалт, хөтөлбөр】

1. Үндэслэл, зорилго

Далайн хог хаягдлын судалгааг явуулахын зэрэгцээ Баруун хойд Номхон далайн бүсийн орон нутгуудын үйл ажиллагаа багтсан далайн хог хаягдал гаралтыг зогсоох тухай дадлага сургалт явуулж дээд эх хэсгээс тэнгисийн эрэг хүртэлх бүсийн хог хаягдлын асуудлын талаарх ойлголтыг нэмэгдүүлж, хүүхэд залуучууд, нутгийн ард иргэд хог хаяхгүй байх, далайн орчныг хэвээр нь хадгалах ухамсар төрүүлж, өдөр тутмын амьдралд хэвшүүлэх дадлыг бий болгоно.

2. Төслийн агуулга

Хүүхэд сурагчид болон ард иргэд далайн хог хаягдлын судалгаа, түүний гаралтыг зогсоох талаар дадлага сургалтад оролцоно. Мөн орон нутгуудаас далайн хог хаягдал болон өрхийн ахуйн хог хаягдал ашигласан бүтээл хийнэ.

(1) Далайн хог хаягдлын судалгаа

а. Хугацаа

2021 оны намар

б. Болох газар

Хөтөлбөрт оролцогч орон нутгуудын далай (эх газрын гол мөрөн хамаархгүй) -н эргийн бүс

в. Явуулах арга

Хөтөлбөрт оролцогч орон нутгууд нутгийн бага, дунд, ахлах сургуулийн сурагчдийг оролцуулан судалгаа, дадлага сургалт явуулна (Эх газрын орон нутгаас цэвэрлэгээ, дадлагын үйл ажиллагааг явуулна)

Хөтөлбөрийн үр дүнг Тояама муж (NPEC) гаргана.

г. Жилийн төлөвлөгөө

5 сард хөтөлбөрт оролцох орон нутгуудыг бүртгэнэ.

9-11 сард судалгааг явуулна

12 сард Тояама муж руу тайланг явуулна.

(2) Далайн хог хаягдлаар бүтээл хийх

а. Хугацаа

Жилийн турш

б. Болох газар

Хөтөлбөрт оролцогч орон нутгуудад

в. Явуулах арга

Тояама мужаас гаргасан зааварчилгийн дагуу тухайн орон нутгийн нөхцөл байдалд тааруулан ард иргэдэд хүүхэд сурагчдын оролцоотой зохион байгуулна.

г. Жилийн төлөвлөгөө

5 сард хөтөлбөрт оролцогч орон нутгуудыг бүртгэнэ.

7-11 сард урлагийн бүтээл хийх

12 сард Тояама муж руу тайланг явуулна.

(3) Найдаж буй үр дүн

「Хог хаяхгүй байх, далайн орчныг сахин хамгаалах ухамсар」 төрүүлэхийн зэрэгцээ ард иргэдийн байгаль орчныг хамгаалах ухамсрыг нэмэгдүүлнэ.

3. Хөтөлбөрт оролцоход тавигдах шаардлага

(1) Тавигдах шаардлага

а. Далайн хог хаягдлын судалгаа

- Хөтөлбөр явуулах газрыг сонгох
- Дадлага сургалт • судалгааны үйл ажиллагаа явуулах төрийн бус байгууллагыг сонгох
- Дадлага сургалт • судалгааны үйл ажиллагаа явуулах байгууллагад зааварчилга өгөх дадлага сургалт, судалгаа явуулах
- Судалгааны үр дүнгийн талаар Тояама мужид тайлагнах

б. Далайн хог хаягдлаар бүтээл хийх

- Үйл ажиллагааны төлөвлөгөө, оролцогчдыг бүртгэх
- Далайн хог хаягдлын судалгааны үйл ажиллагаанд хэрэглэх багаж хэрэгсэл

бэлдэх

- Ард иргэдийн оролцоотой үйл ажиллагаа явуулах, үр дүн, тайланг гаргах

(2) Зардал

а. Зардлыг дараах байдлаар хариуцна.

а. Агуулга

① Далайн хог хаягдлын судалгаа

- Шаардлагатай зардлыг хөтөлбөрт оролцогч орон нутгаас хариуцна.

Зөвхөн шугам, хямсаа, жинлүүр зэрэг судалгаанд шаардлагатай материалын зардал, унааны зардал буюу шатахууны төлбөр, зураг угаалгахад гарах зардлыг Тояама мжаас хариуцна.

② Далайн хог хаягдлаар бүтээл хийх

- Шаардлагатай зардлыг хөтөлбөрт оролцогч орон нутгаас хариуцна.

(3) Төсөл хөтөлбөрт оролцох хүсэлтэй оролцох хүсэлтэй орон нутаг

Хятад : Ляонин муж, Хэбэй муж, Шаньдун муж, Ганьсу муж

Япон : Хоккайдо муж, Аомори муж, Ямагата муж, Нигата муж, Ишикава муж, Фүкүй муж, Киото муж, Хёго муж, Тоттори муж, Шиманэ муж, Ямагүчи муж, Фүкүй муж, Сага муж, Нагасаки муж

Солонгос : Ганвон муж, Чүнчоннам муж, Гёнсаннам муж

Орос : Приморийн хязгаар, Хабаровск хязгаар, Сахалин муж

※ Далайн хог хаягдлын судалгааны үйл ажиллагааг NEAR-ын гишүүн орон нутгуудаас гадна Зүүн хойд Азийн бүсийн тэнгисийн эргийн орон нутгуудад өргөн таниулна.

【Зүүн хойд Азийн бүсийн байгаль орчны сэдэвт зурагт хуудасны үзэсгэлэн】

1. Үндэслэл зорилго

Зүүн хойд Азийн бүсийн ирээдүйг авч явах хүүхэд залуучуудын дунд “Байгаль орчныг сахин хадгалах” сэдвээр зурагт хуудасны уралдаан зохион байгуулж, шилдэг бүтээлээр үзэсгэлэн гаргах ба Зүүн хойд Азийн бүсийн ард иргэдийн байгаль орчныг хамгаалах ухамсрыг нэмэгдүүлнэ.

2. Агуулга

(1) Хугацаа

2021 оны 6 сарын эхээр

(2) Болох газар

Чүнчоннам муж

(3) Явуулах арга

- Төсөл хөтөлбөрт оролцогч орон нутгуудын захиргаа нутгийн хүүхэд сурагчид (Бага • дунд • ахлах ангийн сурагч) -ийг оролцуулах ба шилдэг бүтээлийг шалгаруулна.
- Төсөл хөтөлбөрт оролцогч орон нутгууд шилдэг бүтээлийг төслийг удирдагч орон нутаг (Чүнчоннам муж) руу явуулна.
- Төсөл удирдагч орон нутаг зурагт хуудасны үзэсгэлэн зохион байгуулж, хөтөлбөрт оролцогч орон нутгуудын бүтээлээр үзэсгэлэн гаргана.

(4) Жилийн төлөвлөгөө

3-5 сард бүтээлийг бүртгэнэ. Хөтөлбөрт оролцогч орон нутгуудаас бүтээлийг ирүүлнэ.

6 сарын эхээр зурагт хуудасны үзэсгэлэнг зохион байгуулна (Үзэсгэлэнд тавигдах бүтээлийн тоо : 30)

8 сард хөтөлбөр зохион байгуулсан үр дүн болон үзэсгэлэнд оролцуулсан бүтээлийг вэбсайтаар танилцуулна.

9-10 сард бүтээлийг буцаан явуулна.

(5) Найдах үр дүн

Зүүн хойд Азийн бүсийн иргэдийн байгаль орчныг сахин хадгалах, хамгаалах ухамсар төрүүлнэ.

3. Хөтөлбөрт оролцогч орон нутгуудад тавигдах шаардлага

(1) Агуулга

- Хөтөлбөрт оролцогч орон нутгууд байгаль орчныг сахин хамгаалах сэдэвт бүтээлийг бүртгэж, шилдэг бүтээлийг шалгаруулна.
- Шилдэг бүтээлийг хөтөлбөр зохион байгуулах орон нутаг руу явуулна (5-аас дээшгүй бүтээл, бүтээлийн нэр, уран бүтээлчийн танилцуулга хамт явуулах)
- Шилдэг бүтээлийг хөтөлбөр зохион байгуулах орон нутаг руу явуулна.
※ 2021 оны төсөв гараагүйн улмаас 2021 оны бүтээлийг явуулах боломжгүй тохиолдолд 2020 онд бүртгэсэн бүтээлийг явуулна.
- Шилдэг бүтээлийг цахимаар бүртгэсний дараа хөтөлбөр зохион байгуулагч орон нутаг руу явуулна (Бүтээлийг буцаан явуулах шаардлагатай/шаардлагүйг мэдэгдэнэ)

< Жич : Хөтөлбөр зохион байгуулагч орон нутгаас зохион явуулна >

- Хөтөлбөрт оролцох орон нутагт хөтөлбөрийн зарыг хүргэж, шилдэг бүтээлийг хүлээн авах тухай мэдэгдэнэ.
- Тухайн орон нутаг бүтээлийг бүртгэж, нэгдүгээр шатанд шалгаруулна.
- Орон нутгуудаас ирсэн шилдэг бүтээлээр үзэсгэлэн гаргана.
- Бүтээлийг буцаан авах хүсэлтэй орон нутаг руу үзэсгэлэнгийн дараа бүтээлийг буцаан явуулна.

(2) Зардал

Зардлыг дараах байдлаар хариуцна.

Хөтөлбөрт оролцогч орон нутаг бүтээлийг бүртгэж шалгаруулахад гарах зардал, хөтөлбөр зохион явуулах орон нутаг руу бүтээлийг илгээх шуудангийн зардлыг хариуцна.

Хөтөлбөр зохион байгуулагч тал нь

Бүтээлийн хоёрдугаар шатны шалгаруулалтын зардал

Зурагт хуудасны үзэсгэлэнг таниулахад гарах зардал

Үзэсгэлэн гаргахад гарах зардал

Үзэсгэлэнгийн дараа бүтээлийг эзэнд нь буцаан явуулахад гарах зардлыг хариуцна.

(3) Оролцох хүрээ

NEAR-ын нийт гишүүн орон нутаг

【Далайн эргийн амьд биетийн судалгаа】

1. Үндэслэл, зорилго

Зүүн хойд Азийн бүсийн далайн амьд биетийн олон янз байдлыг хадгалахын тулд тухайн бүсийн амьд биетийн талаар мэдээлэл цуглуулж, газрын гадаргуун дээрх амьд биетийн судалгааг явуулна. Уг судалгаагаар дамжуулан иргэд, хүүхэд залуучуудыг далайн амьд биетийн талаарх сонирхлыг нэмэгдүүлжш байгаль орчныг хамгаалах, амьд биетийн олон янз байдлыг хадгалах ухамсрыг дээшлүүлнэ.

2. Агуулга

(1) Хугацаа

Жилд 1 удаа

(2) Болох газар

Төсөл хөтөлбөрт оролцох орон нутгуудын далайн эрэг (амьд биет олноор байдаг хад, хайрга чулуутай газар тохиромжтой)

(3) Явуулах арга

- NPEC байгууллагаас гаргасан судалгааны зааварчилгын дагуу зохион байгуулж, судалгааны үр дүнг төсөл хөтөлбөрт оролцогч орон нутгуудтай хуваалцана.
- Далайн амьд биетийн талаарх мэдлэгтэй судалгааны байгууллага, NGO/NPO, салбарын мэргэжилтний зааварчилгын дагуу ард иргэд далайн амьд биетийг ажиглан, нэр, зургийг нь тэмдэглэнэ.
- Дэлхийн дулаарал, гадны амьд биетийн нөлөөллөөр гадаргууны амьд биет оршин тогтнож буй эсэхийг судална.
- Судалгааны үр дүнг NPEC байгууллагаас вэбсайтаар мэдээлнэ.

(4) Жилийн төлөвлөгөө

2021 оны 6-7 сард төсөл хөтөлбөрт оролцогчдыг бүртгэнэ.

7-8 сард судалгааг явуулна.

11 сард Тояама муж руу судалгааны үр дүнг явуулна.

(5) Найдах үр дүн

- Зүүн хойд Азийн далайн эргийн амьд биетийн тархалтын байдлыг судлах
- Гадаргуу дээрх амьд биетийн амьдрах цар хүрээг судлах
- Далайн амьд биетийн олон янз байдал, далайн орчныг хамгаалах тухай ухамсрыг төрүүлэх

3 Төсөл хөтөлбөрт оролцох орон нутагт тавигдах шаардлага

(1) Агуулга

- Судалгаа явуулах байгууллага, NGO/NPO болон салбарын мэргэжилтнийг сонгоно.
- Судалгааны байгууллагатай судалгаа явуулах, судалгааны тайлангийн талаар харилцаа холбоог зохицуулах

(2) Зардал

Зардал гарахгүй (Зардал гаргахгүй хэмжээнд зохион байгуулна)

(3) Оролцох хүрээ

Эх газрын орон нутгаас бусад NEAR-ын гишүүн орон нутаг

【Хүүхэд сурагчдын байгаль орчны танин мэдэхүйн “Хясаа-Цэнхэр нүүрстөрөгч” хөтөлбөр

1. Үндэслэл, зорилго

Хүүхэд сурагчдад зориулсан далайн эргийн орчны талаарх танин мэдэхүйн хөтөлбөр явуулж далайн эргийн экологи, цэнхэр нүүрстөрөгчийн ач холбогдлыг ойлгуулж, алайн эргийн экологи орчныг хамгаалахын чухлыг ойлгуулах зорилготой.

2. Агуулга

(1) Хугацаа

2021 оны 6-12 сар (7 сарын хугацаанд)

(2) Болох газар

Төсөл хөтөлбөрт оролцогч орон нутгуудын далайн эрэг

3) Явуулах арга

- ① Зохих хэмжээнд өсч томорсон хясааг түүж, түүний өсөлтийн байдлыг нь шалган(Далайн урсгал дунд байх явцад, судалгаа ажиглалт явуулах явцад, цуглуулахдаа хэмжилт хийх) нүүрстөрөгчийн тогтсон хэмжээг судална.

- ② Хясаа өсч томрох хүртлээ усан дахь нүүрстөрөгчийг биедээ хуримтлуулах, нүүрстөрөгчийг тогтоох явцыг судална.

<Судалгааны жишээ >

- Хясаа ус цэвэршүүлэх үйлчилгээтэйг судална

- Түүсэн хясаагаар хоол хийх • амталгаа хийх

(Нүүрстөрөгчийг эргэлтэд оруулах<Үржүүлэг(Үйлдвэрлэх)→ Түүх(Барих)→ Хоол хүнс(хэрэглээ зарцуулалт)>-ын талаарх судалгаа)

- Хясааны олдворын музей үзэх

(Хаягдал хясааны ном сурах бичиг ашиглан цэнхэр нүүрстөрөгчийн тухай ойлголттой болох)

- Цэнхэр нүүрстөрөгчийн тухай гарын авлага хийж, тараах

- ③ Үр дүнг тайлагнах

(4) Жилийн төлөвлөгөө

Орон нутгийн байдалд тохируулан хясааг үржүүлэх, нүүрстөрөгчийн тогтсон хэмжээг судлах, байгаль орчны сургалт явуулна.

【Хясааг ашиглах жишээ】

7 сар хүртэл хясааг үржүүлэх, усанд тавих

11 сар хүртэл нүүрстөрөгчийн тогтсон хэмжээ (Хясаа өсч томорсон



<Хясааг усанд тавьсан(зүүн)-ы дараа, өсч томорсон хясааг түүнэ>



<Хясаа ус цэвэршүүлж байгааг туршилтаар шалгана >



<Түүсэн хясаагаар амтат хоол хийнэ.>



<Хүрэл зэвсгийнүеийн хясааны олдвор(цэнхэр нүүрстөрөгчхадгалсан) үзэх>

тохиолдолд) судална, дадлага хийнэ.

12 сард тайланг гаргана.

(5) Найдах үр дүн

- Уур амьсгалын өөрчлөлт, дайлан орчныг хамгаалах тухай ойлголтыг нэмэгдүүлэх
- Цэнхэр нүүрстөрөгчийн талаарх ойлголтыг нэмэгдүүлэх, байгаль орчны сургалтад цэнхэр нүүрстөрөгчийг идэвхтэй ашиглах
- Хясааны бодис, агууламж зэрэгт анализ хийж агаарын бохирдол бууруулах арга хэмжээг гаргана.
(Чүнчоннам муж) үндсэн материалд ашиглах (Өөр орон нутагт жишээ материал болно)

3 Төсөл хөтөлбөрт оролцох орон нутгуудад тавигдах шаардлага

(1) Агуулга

• Орон нутгуудын хөтөлбөрийн төлөвлөгөө гаргана, оролцогчдыг бүртгэх, холбогдох салбарын төлөөллийг

- Хөтөлбөрийг явуулах
- Хөтөлбөрийн тайлан гаргах

(2) Зардал

Газар дээр нь судалгаа хийх болон танин мэдэхүйн хөтөлбөрт ашиглах хэрэгслийг авах зардлыг хариуцна.

(3) Оролцох хүрээ

NEAR-ын зарим гишүүн орон нутаг (Далайд ойр зэргэлдээ орших орон нутаг)

“Eco-selfie – Байгаль орчныг хамгаалах үйл ажиллагаа сельфи зурагт” гэрэл зургийн уралдаан

1. Үндэслэл, зорилго

Байгаль орчныг хамгаалах талаар гэрэл зургийн уралдаан зохион байгуулж, байгаль орчныг хамгаалах үйл ажиллагаанд иргэдийг оролцуулан байгаль орчныг хамгаалах соёлыг бий болгоно.

2. Агуулга

(1) Хугацаа

2021 оны 6-12 сар

(2) Болох газар

Томск муж

(3) Явуулах арга

① Төсөл хөтөлбөрт оролцогч орон нутгуудаас байгаль орчныг хамгаалах сэдэвт гэрэл зургийг бүртгэнэ.

○ Байгаль орчныг хамгаалах чиглэлийн гэрэл зураг

• Мод тарих, байгаль орчны цэвэрлэгээ хийх, цэвэр гол усны сэдэвт гэрэл зураг

○ Гэрэл зурагт тавигдах шаардлага

• JPG, JPEG форматаар авсан гэрэл зургийг файлаар явуулах

• Хүрээ хийх, нэмэлт эффект, засвар, нэмэлт функц өгсөн зургийг тооцохгүй.

○ Ангилал

• Сургуулийн өмнөх насны хүүхэд (Асран хамгаалагчидтай хамт авахуулсан

зураг)

• Хүүхэд • сурагч (Бага, дунд, ахлах сургууль)

• Оюутан (Их дээд сургуулийн оюутан)

• Жирийн иргэд

② Хөтөлбөрт оролцогч орон нутгуудаас бүртгэсэн зургийг Томск мужийн захиргаа болон NPEC байгууллага руу явуулна.

③ Томск мужийн захиргаанаас гэрэл зургийн өгүүлэмж, бүтээлч сэтгэлгээ, байгаль орчныг хамгаалах илэрхийлэл зэргийг дүгнэж, шилдэг бүтээлд шагнал өргөмжлөл олгоно.

④ Томск мужийн захиргаанаас шилдэг байрын шагнал, нийт оролцогчдод оролцсон тухай батламжийг файлаар явуулна.

⑤ Төсөл хөтөлбөрт оролцон нутгийн захиргаанаас шагнал, батламжийг шуудангаар уралдаанд оролцогчид руу явуулна

⑥ Томск мужийн захиргаанаас SNS буюу сошиалаар шилдэг бүтээлийг танилцуулна.

(4) Ж илийн төлөвлөгөө

6-10 сард төсөл хөтөлбөрт оролцогч орон нутгуудын захиргаа уралдаанд оролцогчдыг бүртгэж, Томск мужийн захиргаа дараагаар нь бүртгэнэ.

11 сард уралдааны шалгаруулалт явагдана.

12 сард шагналыг явуулж, SNS буюу сошиалаар шилдэг бүтээлийг танилцуулна.

(5) Найдах үр дүн

Иргэд байгаль орчныг хамгаалах үйл ажиллагаанд идэвхтэй оролцоно гэдэгт найдаж байна.

3 Төсөл хөтөлбөрт оролцогч орон нутгуудад тавигдах шаардлага

(1) Төсөл хөтөлбөрт оролцогч орон нутгууд бүтээлийг бүртгэж Томск мужийн захиргаа

руу явуулах, уралдааны шагнал, бэлэг дурсгалын зүйлийг шагналт байрын эзэд рүү явуулах

(2) Зардал

Төсөл хөтөлбөрт оролцогч орон нутагт уралдаанд оролцох бүтээлийг бүртгэхэд гарах зардал, уралдааны шагналт байрын эзний шагналыг шуудангаар явуулахад гарах зардалыг хариуцан гаргана.

(3) Оролцох хүрээ

NEAR нийт гишүүн орон нутаг, мөн өөр бусад орон нутаг

(3) Төсөл хөтөлбөрт оролцох хүсэлтэй орон нутгуудын жагсаалт (◎ : Төслийг

санаачлагч орон нутаг ○ : Төсөл хөтөлбөрт оролцох хүсэлтэй орон нутаг)

Орон нутаг* ¹		Төсөл	Байгаль орчны үйл ажиллагааны манлайлагч	Далайн хог хаягдлын судалгаа* ²	Зурагт хуудасны үзэсгэлэн	Далайн эргийн амьд биетийн судалгаа	Цэнхэр нүүрстөрөгч	Гэрэл зургийн уралдаан
Хятад	Шаньси муж		○	—	—	—	—	—
	Ляонин муж		○	—	—	—	—	—
Япон	Тояама муж		◎	◎	○	◎	○	○
	Ишикава муж		—	○ S	—	—	—	—
	Фүкүй муж		—	○	—	○	—	—
	Киото муж		—	○ S	—	—	—	—
	Тоттори муж		—	○ S	—	○	—	—
	Шиманэ муж		—	○ S	—	—	—	—
	Ямагүчи муж		—	○ S	—	—	—	—
	Сага муж		—	○ S	—	—	—	—
Солонгос	Ганвон муж		○	○ S	○	—	—	○
	Чүнчоннам муж		○	○ S	◎	—	◎	○
	Гёнсаннам муж		○	○ S	—	—	—	—
Монгол	Баянхонгор муж		—	—	○	—	—	○
	Дундговь муж		—	—	○	—	—	○
Орос	Приморийн хязгаар		○	○	○	○	○	○
	Хабаровск хязгаар		○	○	○	○	○	○
	Томск муж		○	—	○	—	—	◎
	Амур муж		—	—	—	—	—	○
	Сахалин муж		○	○	○	○	—	○
	Кемеров муж		—	—	—	—	—	○
Төсөлд оролцох хүсэлтэй орон нутгийн тоо			4 улс, 10 орон нутаг	3 улс, 15 орон нутаг	4 улс, 9 орон нутаг	2 улс, 6 орон нутаг	3 улс, 4 орон нутаг	4 улс, 11 орон нутаг

*1. Доогуур зураас татсан орон нутаг : ЗХАНЗХ (NEAR) -ны гишүүн бус орон нутаг

* 2 ○ S : Далайн хог, хаягдлын судалгаа ба далайн хог хаягдлаар бүтээл хийх, зөвхөн онлайнаар зохионо.

3 Хорооны дараагийн зохицуулагчаар ажиллах орон нутгийн судалгааны үр дүн

2019 оны 7 сараас Тояама мужийн захиргаа NEAR-ын Байгаль орчны хорооны зохицуулагчаар ажиллаж ирсэн бөгөөд 2021 оны 7 сараар хугацаа нь дуусах юм. Иймд хорооны дараагийн зохицуулагчаар ажиллах хүсэлтэй орон нутгийн судалгааг явуулсан ч хорооны дараагийн зохицуулагчаар ажиллах хүсэлтэй орон нутаг Тояама мужаас өөр байгаагүй.

4 Байгаль орчны хорооны үйл ажиллагааны төлөвлөгөө (2021 он)

Хугацаа	Агуулга
Тохиромжтой хуагцаа	<ul style="list-style-type: none">○ Төсөл санаачлагч орон нутаг болон төсөлд оролцох хүсэлтэй орон нутаг төслийн талаар зөвшилцөнө.○ Зөвшилцсөний дараа тухайн нөхцөл байдалд тааруулан төслийг явуулна.
8 сар~	<ul style="list-style-type: none">○ Хороог зохицуулагч орон нутаг 2021 оны төслийн хэрэгжилтийн байдал болон 2022 оны төслийн саналын талаарх судалгааг явуулж үр дүнг нь гаргана.
Намар	<ul style="list-style-type: none">○ Байгаль орчны хорооны 15-р хурал (Агуулга) • Хорооны дараагийн зохицуулагч орон нутгийг сонгох<ul style="list-style-type: none">• 2021 оны төслийн хэрэгжилтийн байдал• 2022 оны төслийн санал• Орон нутгуудын байгаль орчны бодлогын талаарх мэдээлэл солилцох
Өвөл	<ul style="list-style-type: none">○ Зохицуулагч орон нутгаас 2022 оны төсөлд оролцох орон нутгуудын судалгааны үр дүнг гаргана.